



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/209

Булган сум

### Жүдо бөхийн хойд бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулахад хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.10 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, 2025 оны XII хуралдааны “Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай” XII/90 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2026 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардал батлах тухай” А/97 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өсвөр үеийн тамирчдын бие бялдрын хөгжлийг дэмжих, жүдо бөхийн спортыг түгээн дэлгэрүүлэх, тэдний ур чадвар, авьяас чадварыг нээн хөгжүүлэх зорилгоор Хойд бүсийн өсвөрийн жүдо бөхийн тэмцээнийг Булган суманд 2026 оны 03 дугаар сарын 30-31-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 10,036,000 (арван сая гучин зургаан мянга) төгрөгийг хавсралтаар баталсугай.

3.Дээрх хөрөнгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

03  
А/209  
Аймгийн Засаг даргын 2026 оны  
дугаар сарын 26-ны/ний өдрийн  
дугаар захирамжийн хавсралт

ХОЙД БҮСИЙН ЖУДО БӨХИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ  
ТЭМЦЭЭНИЙ ТӨСӨВ

Д/д	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5
1	Медаль	218ш	10,000	2,180,000
2	Өргөмжлөл	6	80,000	480,000
3	Өргөмжлөл	212	3,000	636,000
4	Багийн шагнал	1-р байр-2 2-р байр-2 3-р байр-2	500,000 400,000 300,000	1,000,000 800,000 600,000
5	Цом	6	100,000	600,000
6	Хулдаасан хэвлэл	30м <sup>2</sup>	18,000	540,000
7	Шүүгч цалин	3 өдөр	200,000	600,000
8	Шүүгч байр хоол	10хүн 3 өдөр	60,000	1,800,000
9	Шүүгч зам зардал	10 хүн	80,000	800,000
<b>НИЙТ</b>				<b>10,036,000</b>

--o00o--